



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/680

Улаанбаатар хот

Барилга акталж, данснаас
хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл, 78 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны “Барилга акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасах тухай” 57 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 57 дугаар тогтоолын дагуу Багахангай дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсийн балансад бүртгэлтэй, нийт 425,257,100.86 (дөрвөн зуун хорин таван сая хоёр зуун тавин долоон мянга нэг зуун төгрөг наян зургаан мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ, 340,504,962.54 (гурван зуун дөчин сая таван зуун дөрвөн мянга есөн зуун жаран хоёр төгрөг тавин дөрвөн мөнгө) төгрөгийн үлдэх өртөг бүхий хавсралтад дурдсан барилгыг акталж, данс бүртгэлээс хасахыг Багахангай дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэс (Б.Өлзийбат)-т зөвшөөрсүгэй.

2. Акталж, данс бүртгэлээс хасах барилгыг нурааж буулгахад хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах ажлыг зохион байгуулахыг Хяналт шалгалтын газар (С.Төмөрдулам)-т үүрэг болгосугай.

3. Барилгын хоёрдогч түүхий эдийн зориулалтаар дахин ашиглах боломжтой эд хөрөнгийг худалдан борлуулж 8,380,000.0 (найман сая гурван зуун наян мянган) төгрөгийг Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Нийслэлийн төрийн сангийн 100200051024 тоот дансанд төвлөрүүлэхийг Багахангай дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэс (Б.Өлзийбат)-т, орлого төвлөрүүлэлтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т тус тус даалгасугай.

4. Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (Л.Хосбаяр)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

1110203175



АКТАЛЖ, НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ БАРИЛГЫН ЖАГСААЛТ

№	Барилга байгууламжийн нэр	Ашиглалтад орсон он	Байршил	Бүртгэлийн үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг /2024.05.30-ны байдлаар/	Акталж, данснаас хасах үндэслэл
1	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсийн барилга	1981	Багахангай дүүрэг 1 дүгээр хороо	425,257,100.86	84,752,138.32	340,504,962.54	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн 2022 оны 02-07-395/468 дугаар дүгнэлтийг үндэслэн барилгыг нурааж шинээр барилга барих
НИЙТ ДҮН							340,504,962.54